

Есүс амилсаны дараа дагалдагч нар нь Бурханы үгийг хичээнгүйлэн дамжуулж эхэлсэн.

Есүсийн дагалдагч нар Бурханы үгийг дамжуулж эхэлснээр итгэгч хүмүүс бага багаар нэмэгдэж байв.

Дагалдагч нар сүмийн ажлыг даалгахын тулд долоон үйлчлэгчийг сонгов.

Тэр дунд итгэлийн хувьд маш сайн Стефан гэгч хүн байв. Стефаны нэр нь “Алдарын титэм” гэсэн утгатай байв.

Стефанаар дамжуулан Бурханы олон гайхамшигууд бий болсон. Тэр чөтгөрийг зайлуулж, өвчтэй хүнийг эдгээж байв.

Тиймээс олон хүмүүс түүнийг дагав. Стефан Бурханы өгсөн мэргэн ухаанаар олон хүнд үгийг дамжуулж тайлбарлаж байв.

Түүнийг дагах хүмүүсийн тоо ч ихсэж байлаа.

Гэтэл нэгэн өдөр Стефанд атаархаж дургүйцдаг хүмүүс түүнийг Иудейн удирдагч нарт гүтгэн ховлов.

“Стефан Бурханы үгийг зөрчсөн” гэж худал ховлов. Стефан Иудейн удирдагчийн өмнө чирэгдэн очив.

Тэр газар цугларсан хүмүүс Стефаныг хараад зогсож байв.

Гэтэл Стефаны царай тэнгэр элч адил маш амар тайван харагдаж байв.

Тэр үеийн Иудейн шашинд Бурханы үгийг эсэргүүцвэл чулуу шидэж алдаг хуультай байлаа.

Стефаныг үзэн яддаг хүмүүс Стефанд атаархсандаа энэ үхлээр үхээсэй хэмээн бодсон учраас ингэж барьж өгсөн байлаа.

Стефан хэнээс ч айлгүйгээр маш зоригтойгоор Бурханы үгийг дамжуулж эхлэв. Хүмүүс Стефан уруу чулуу шидэлж эхлэв.

Стефан өвдөг сөгдөн залбирав. “Эзэн минь, намайг хүлээн аваач, харин энэ хүмүүсийг үучилж өгөөч.”

Ингээд Стефан амьсгал хураав. Стефан үхэх хүртлээ Бурханы үгийг дамжуулж байлаа.

Тэрээр анхны чуулганы үед Бурханы төлөө амиа зориулсан анхны хүн болсон юм.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултанд хариулаарай.

а. Элч нар чуулганы ажлыг даалгахын тулд хэдэн үйлчлэгчдийг сонгосон бэ?

-----

б. Стефан ямар хүн байсан бэ? Түүний нэрний утга нь юу вэ?

-----

с. Стефан хэрхэн амиа золиосолсон бэ? Түүний хэлсэн хамгийн сүүлчийн үг юу байсан бэ?

-----

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Үйлс 7:29)

Тэд Стефан уруу чулуу шидэлж байхад Стефан Эзэнийг дуудан, Эзэн Есүс минь,  
сүнсийг минь хүлээн аваарай гэв.

Бүтээлч байцгаа 2. Зурагт нуугдсан 5 зургийг олоорой.

Сантагийн малгай, сагсан бөмбөг, могой, бэйсболлын цохиур, дун

